



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/121

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Аймгийн онцгой комиссын 28 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны 3 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор, Засгийн газрын Хөдөө аж ахуйн салбарын 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 19 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нөөцөд 2020-2021 оны тэжээл бэлтгэн нийлүүлэхээр шууд гэрээ байгуулан ажиллаж байгаа “Аж мандалт Ховд” ХХК-д гэрээний дагуу үлдэгдэл 20 хувийн санхүүжилт болох 7.470.000 төгрөгийг олгосугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 7.470.000 сая төгрөг /долоон сая дөрвөн зуун далан мянган/ -ийг аймгийн өвс, тэжээлийн нөөцийн санхүүжилтээс олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ